



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 08


Арзайхээр

Г Нэр дэвшүүлэх тухай Т

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1, 27.3 дэх хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7.2, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3.5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Сонгон шалгаруулалтын тайлан, шалгалтын нэгдсэн үнэлгээг хянаж үзээд төрийн албаны тусгай шалгалтад тэнцэж хамгийн өндөр оноо авсан Зоригтын Цэцэгмааг Хужирт сумын Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлсүгэй.

2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь заалтын дагуу 3. Цэцэгмаагийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулж, нэр дэвшүүлсэн албан тушаалд томилохыг Хужирт сумын Засаг дарга (Т.Баярмөнх)-д санал болгосугай.



Ц.ГАНБОЛД

0131006-6



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛ

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,
Утас/Факс: 7032 2073, 7032 3538

2020. 05. 19 № 3/27
танай _____ -ны № _____ -т

Г ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Т.БАЯРМӨНХӨД

Төрийн албаны тусгай шалгалтад тэнцсэн
Зоригтын Цэцэгмааг Хужирт сумын Засаг даргын
Тамгын газрын даргын албан тушаалд
томилуулахаар “Нэр дэвшүүлэх тухай” Төрийн
албаны зөвлөлийн Өвөрхангай аймаг дахь салбар
зөвлөлийн 2020 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн
08 дугаар тогтоолыг хүргүүлэв.

Авлигын эсрэг хуулийн 10.3 дахь заалтын дагуу
3. Цэцэгмаагийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг тухайн
албан тушаалд томилогдсон өдрөөс хойш 30
хоногийн дотор гаргуулж эрх бүхий албан тушаалтанд
бүртгүүлэхийг мэдэгдье.

ДАРГА И.ГАНБОЛД

УДЗСН 115
13

013500156

D:My Doc. A5 alban bichig /ZDTG/



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Т.БАЯРМӨНХ ТАНАА

МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2020.06.08 № 05/6695

таний _____-ны № _____-т

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлэг хянасан тухай

Өвөрхангай аймгийн Хужирт сумын Засаг даргын Тамгын газрын даргаар томилогдохоор нэр дэвшсэн Зоригтын Цэцэгмаагийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч нь тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй.

Түүнчлэн Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3, Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргахыг анхаарна уу.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРИА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР *[Signature]*

X.ХАШБААТАР

УХД0422 5120829